



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 181

Төрийн ордон, Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:


1. Цэргийн цол олгох журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 41 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.
3. Цэргийн алба хаагчдын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг энэхүү журамтай нийцүүлэх, цэргийн цол олгохдоо албан тушаалын дамжаатай уялдуулах арга хэмжээг 2015 оны 4 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэхийг Батлан хамгаалахын сайд /Ц.Цолмон/, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга /хошууч генерал Д.Даваа/, Хил хамгаалах ерөнхий газрын дарга /хошууч генерал Ш.Лхачинжав/, Онцгой байдлын Ерөнхий газрын дарга /бригадын генерал Т.Бадрал/ нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ

ХУУЛБАР ҮНЭН:

Тамгын газрын дэд дарга



Б.Нэргүй

ЦЭРГИЙН ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цэргийн цол нь цэргийн алба хаагчийн эрхэлж байгаа албан тушаалын ангиллын илэрхийлэл бөгөөд тэр нь тухайн цэргийн алба хаагчийн цэргийн боловсрол, мэргэшлийн төвшин, цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанд харгалзуулсан зэрэг дэв мөн.

1.2. Цэргийн цолыг зөвхөн Монгол Улсын цэргийн байгууллагад цэргийн тангараг өргөж, цэргийн алба хааж буй цэргийн жинхэнэ алба хаагчид олгоно.

1.3. Цэргийн жинхэнэ алба хаагчийн албан тушаал бүр цэргийн цолны зэрэглэлтэй байх бөгөөд албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Хилийн ба Дотоодын цэргийн дарга, Онцгой байдлын Ерөнхий газрын дарга нар тогтооно.

(Тайлбар. Дотоодын цэргийн тухай хууль батлагдаж, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид Улсын Их Хурал өөрчлөлт оруулснаар Дотоодын цэрэгт энэхүү цол олгох журам үйлчилж эхэлнэ.)

1.4. Цэргийн жинхэнэ алба хаагчдад албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг үндэслэн цэргийн цолыг шат дараалан олгоно.

1.5. Цэргийн цол нь цэргийн алба хаагчдын мөнгөн болон материаллаг хангалтын хэмжээг тодорхойлох эрх зүйн үндэслэл болно.

Хоёр. Цэргийн цол олгох

2.1. Дор дурдсан албан тушаалтнууд өөрийн эрхлэх хүрээний цэргийн алба хаагчдад энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан хүснэгт 1-д заасан цэргийн цолыг олгоно. Эрх олгогдоогүй албан тушаалтан цэргийн цол олгохыг хориглоно.

Хүснэгт 1

Эрх бүхий албан тушаалтан	Олгох цэргийн цол
Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч	Дээд офицерын цол: бригадын генерал, хошууч генерал, дэслэгч генерал, генерал
Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга	Ахлагчийн цол: дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч, сургагч ахлагч, тэргүүн ахлагч Офицерын цол: дэслэгч, ахлах дэслэгч, ахмад, хошууч, дэд хурандаа, хурандаа
Хилийн ба Дотоодын цэргийн дарга	Ахлагчийн цол: дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч, сургагч ахлагч, тэргүүн ахлагч Офицерын цол: дэслэгч, ахлах дэслэгч, ахмад, хошууч, дэд хурандаа
Онцгой байдлын Ерөнхий газрын дарга	Ахлагчийн цол: дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч, сургагч ахлагч, тэргүүн ахлагч Офицерын цол: дэслэгч, ахлах дэслэгч, ахмад, хошууч, дэд хурандаа
Цэргийн нэгтгэл, анги,	Хугацаат болон гэрээт цэргийн цол: байлдагч, ахлах

байгууллагын захирагч,
дарга

байлдагч, дэд түрүүч, түрүүч, ахлах түрүүч
Ахлагчийн цол: ахлагч, ахлах ахлагч

2.2. Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчид цэргийн цол олгох асуудлыг цэргийн нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нар шийдвэрлэх буюу цол олгох үндэслэл, тодорхойлолт, саналаа удирдах дээд байгууллагад уламжилна.

2.3. Офицерын цолыг хүснэгт 2-т заасан хугацааг баримтлан анхны цолоос эхлэн дэс дараалан олгоно.

Хүснэгт 2

д/д	Цэргийн цол	Цэргийн цолны хоорондын хугацаа
1	Дэслэгч – ахлах дэслэгч	36 сар буюу 3 жил
2	Ахлах дэслэгч – ахмад	36 сар буюу 3 жил
3	Ахмад – хошууч	48 сар буюу 4 жил
4	Хошууч – дэд хурандаа	60 сар буюу 5 жил
5	Дэд хурандаа – хурандаа	60 сар буюу 5 жил

2.4. Офицерын цол нь томилогдож буй албан тушаалын цолны зэрэглэлээс хоёр, түүнээс дээш зэрэглэлээр доогуур байвал түүний цэргийн цолыг эхний ээлжинд нэг шат ахиулж, дараагийн цолыг албан тушаалын доод зэрэглэлийн цол хүртэл дэс дараалан олгох бөгөөд цолны хоорондын хугацаа нь гурван жилээс доошгүй байна.

2.5. Цэргийн хоёр цолны зэрэглэлтэй албан тушаалд цэргийн алба хаагчийг томилохдоо доод зэрэглэлийн цолыг олгосон бол дунд офицерт 3 жил, ахлах офицерт 4 жил ажилласны дараа албан тушаалын дээд зэрэглэлийн цол олгоно.

2.6. Ажлын үзүүлэлт хангалтгүй гэж үзвэл цол олгох албан тушаалтан албан тушаалын дээд зэрэглэлийн цол олгох хугацааг дахин нэг жилээр хойшлуулж болно.

2.7. Цэргийн бэлтгэл үүрэгтэнд цол олгохдоо түүний дайчилгааны сургууль, цугларалт, хээрийн сургуульд оролцож эзэмшсэн цэргийн мэргэжил, томилгоот албан тушаалын цолны зэрэглэлийг үндэслэл болгоно. Харин чөлөөнд байгаа офицер ахлагчид ямар ч тохиолдолд цэргийн цол ахиулж олгохгүй.

2.8. Цэргийн албаны ахлах офицерын “хурандаа” цолыг зөвхөн Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга олгоно.

2.9. Цэргийн алба хаагчид “хурандаа” цол олгохдоо түүний цэргийн жинхэнэ алба хаасан хугацаа, цэргийн анги байгууллагад ажилласан, цэргийн дээд боловсрол эзэмшсэн байдал болон энэхүү журмын 2.18-д заасан шалгуурыг үндэслэл болгоно.

2.10. Цэргийн албаны дээд офицерын цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч олгоно.

2.11. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, түүний орлогч нараас бусад дээд офицерын албан тушаалын ангилал, цолны зэрэглэл бүхий албан тушаалтанд дээд офицерын цол олгох саналыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын Засгийн газарт уламжилна. Монгол Улсын Засгийн газар уг саналыг танхимынхаа хуралдаанаар хэлэлцэж дэмжвэл Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

2.12. Дээд офицерын цол олгох насны доод хязгаар 45 нас байна.

2.13. Цэргийн ахлагчийн албаны анхны “дэд ахлагч” цолыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Хилийн ба Дотоодын цэргийн дарга, Онцгой байдлын Ерөнхий газрын дарга нар олгоно.

2.14. Цэргийн ахлагчийн албаны “ахлагч”, “ахлах ахлагч” цолыг цэргийн

нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга олгоно.

2.15. Цэргийн ахлагчийн албаны "сургагч ахлагч", "тэргүүн ахлагч" цолыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга олгоно.

2.16. Цэргийн гэрээт болон хугацаат албаны алба хаагчдын цэргийн цолыг цэргийн нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга олгоно.

2.17. Цэргийн цол олгох эрх бүхий албан тушаалтан цэргийн алба хаагчид цэргийн цол олгохдоо албан тушаалын цолны зэрэглэл, боловсрол эзэмшсэн, ажилдаа мэргэшсэн байдал, ажлын үзүүлэлт, офицер /ахлагч/-ийн ёс зүй зэрэг шалгуурыг багтаасан албан тодорхойлолтыг үндэслэл болгоно.

2.18. Цэргийн ахлагчийн албаны цэргийн цолны хоорондын хугацаа 3 жил байна.

2.19. Цэргийн ахлагчийн албаны цэргийн цол нь томилогдож буй албан тушаалын цолноос хоёроос дээш зэрэглэлээр доогуур байвал дараагийн цэргийн цол олгох хугацаа нь нэг зэрэглэлийн зөрүүтэй болох хүртэл 2 жил байна. Нэг зэрэглэлээр доогуур үед 2.17 дахь заалтыг мөрдөнө.

2.20. Цэргийн албаны офицер, ахлагчийн цэргийн цол нь томилогдож буй албан тушаалын цолны зэрэглэлээс дээгүүр байвал алба хаагч тухайн томилогдсон албан тушаалын цэргийн цолыг хэрэглэнэ.

2.21. Цэргийн албаны дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч тогтооно.

2.22. Дээд офицерын цол нь томилогдож буй албан тушаалын цолны зэрэглэлээс дээгүүр байвал тухайн цолоо хэрэглэх дээд хугацаа нь 1 жил байна.

2.23. Иргэний байгууллагад ажиллаж байгаад цэргийн албаны офицер, ахлагчийн албан тушаалд томилогдсон иргэн дунд, ахлах офицерын болон ахлагчийн албан тушаалд томилогдвол эхний ээлжинд энэ журмын 2.1, 2.13 дахь заалтыг, дараагийн цолыг олгохдоо энэхүү журмын 2.14, 2.15, 2.18 дахь заалтуудыг тус тус баримтална.

2.24. Цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан бэлтгэл үүрэгтэн цэргийн албаны офицер, ахлагчийн албан тушаалд дахин томилогдвол эхний ээлжинд түүний халагдахаас өмнө хэрэглэж байсан сүүлийн цолыг сэргээж, цаашид энэ журмын 2.14, 2.15, 2.17 дахь заалтыг баримтлан цэргийн цол олгоно.

2.25. Цэргийн академи, их, дээд сургуульд сурч байгаа болон төгсөж ирсэн офицер ахлагчид цол олгох асуудлыг тухайн сонсогч, сурагчийн сурлага, сахилгын байдлыг харгалзан энэ журмын дагуу шийдвэрлэнэ.

2.26. Эрхэлж буй албан тушаалдаа үлгэр жишээчээр ажиллаж, өндөр амжилт гаргасан офицер ахлагчийн цэргийн ээлжит цолыг цол олгох эрх бүхий албан тушаалтан энэ журмын 2.17 дахь заалтыг баримтлан хугацааны өмнө олгож болно.

Гурав. Цэргийн цолыг хэрэглэх

3.1. Цэргийн алба хаагч цэргийн жинхэнэ алба хааж байхдаа, цэргийн бэлтгэл үүрэгтэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцох үедээ цэргийн цолыг хэрэглэнэ.

3.2. Цэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн цолны өмнө "бэлтгэл", цэргийн бэлтгэл албанд байх нас хэтэрсэн, эрүүл мэндээр цэргийн албанд тэнцэхгүй гэсэн эмнэлгийн дүгнэлт гарсан бэлтгэл үүрэгтний цэргийн цолны өмнө "чөлөөнд байгаа" гэсэн тодотгол хэрэглэнэ.

3.3. Цэргийн албаны тангараг өргөсөн цэргийн жинхэнэ алба хаагч, цэргийн бэлтгэл үүрэгтнээс бусад төрийн болон төрийн бус байгууллагын алба хаагчид цэргийн цол хэрэглэхийг хориглоно.

3.4. Цэргийн алба хаагч, цэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн цолд хүндэтгэлтэй хандаж, захирах, захирагдах ёсыг чандлан биелүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Цэргийн цолыг бууруулах, хураан авах, сэргээх

4.1. Цэргийн цол олгох эрх бүхий албан тушаалтан Монгол Улсын хууль, "Цэргийн сахилгын дүрэм"-д заасны дагуу цэргийн алба хаагчийн цэргийн цолыг бууруулж болно.

4.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч дээд офицерын цол бүхий албан тушаалтны цолыг энэ журмын 4.3 дахь заалтыг үндэслэн бууруулж болно.

4.3. Дээд офицерыг цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх, цэргийн жинхэнэ албанд эргүүлэн авах, дээд офицерын цолны зэрэглэлгүй албан тушаалд томилж цэргийн цол бууруулах, дээд офицерын цэргийн цолыг хасах буюу сэргээн олгох бол ЗХЖШ-ын дарга энэ тухай санал боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

4.4. Монгол Улсын Зэвсэгт хүчинд болон Монгол Улсын цэргийн байгууллагад цэргийн жинхэнэ алба хааж байгаад гадаад улсын харьяат болсон цэргийн алба хаагчийн цэргийн цолыг уг цолыг олгосон албан тушаалтан хураан авна.

4.5. Гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн, цэргийн дүрэм, сахилгыг удаа дараа зөрчсөн цэргийн жинхэнэ алба хаагчийн цэргийн цолыг уг цолыг олгосон албан тушаалтан хураан авна.

4.6. Хуульд заасан офицер, ахлагчийн насны дээд хязгаарт хүрч, цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэнд цэргийн цолыг сэргээн олгохгүй.

--oOo--

